ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН 7 ХОНОГИЙН МЭДЭЭ
/2020.03.30-2020.04.03/

2020.04.03 Дархан-Уул аймаг

№	Ажлын чиглэл	Гүйцэтгэсэн ажил
		Барилга, хот байгуулалтын хэлтэс
1	Барилгын чиглэл	✓ Барилга угсралтын тусгай зөвшөөрөл шинээр авах хүсэлт гаргасан “Ган говь хийц” ХХК, “Эм Си Ар Эл” ХХК-дад шинээр батлагдсан хууль тогтоомжийг танилцуулж Монголын барилгын үндэсий ассоциацид дэмжсэн бичгийг гаргаж өгсөн. ✓ Дархан сумын 8-р багт байрлах "Өгөөж чанар" ХХК-ний үйлчилгээтэй 79-н айлын нийтийн орон сууцны барилгад ХЭБАЭ-ийн зааварчилгааг өгч батлуулан барилгын ажил үргэлжлүүлэх зөвшөөрлийг олгосон.
2	Хот байгуулалтын кадастрын зураглал	✓ Хот байгуулалтын кадастрын мэдээллийн санд 6 барилга байгууламжийн мэдээлэл оруулсан ✓ Архитектур төлөвлөлтийн даалгаварын төсөл 2-р боловсруулж 1-г батлуулсан ✓ Угсармал орон сууцны мэдээллийн судалгаа ✓ Дахин төлөвлөлтийн төлөвлөгөөний төсөл боловсруулах
3	Барилга, Инженерийн дэд бүтцийн чиглэл	✓ Дархан Улаанбаатар чиглэлийн 204км авто замын ажилтай холбоотойгоор тойргийн уулзвараас Цайдам хүртэлх замын трассд орсон инженерийн шугам сүлжээ, газар олголтын судалгааг ХОХБТХ-д хүргүүлсэн. ✓ Бүтээн байгуулалтын хуралд оролцож захиалагчийн хяналт хийгдэж байгаа 5 барилга байгууламжийн явцыг танилцуулсан. ✓ Эс энд эй трэйд ХХК болон Дорнын өргөө ХХК-ны барилга угсралтын ажилд БХТ-тэй хамтарсан хяналт хийсэн.
4	Барилгын материал үйлдвэрлэлийн чиглэл	✓ Мэдээг Барилгын хөгжлийн төв болон, Барилгын материл үйлдврэлэгчдийн холбоонд 2020.03.27-ны 264 тоотоор хүргүүллээ. Дархан-Уул аймагт Барилгын материалын үйлдвэрлэл эрхэлж байгаа 29 ААНБ-уудаас Барилга, Хот байгуулалтын сайд, Үндэсний статистикийн хорооны даргын хамтарсан 2019,12,18-ны өдрийн 206, А/184 тоот тушаалаар батлагдсан маягтын дагуу 2019 оны мэдээг хүлээн авсан. 21 мэдээ ирсэн байна. 8 ААНБ бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн мэдээ ирүүлээгүй байна.
		Газрын удирдлагын хэлтэс
1	Суурь судалгаа, газрын мониторингийн чиглэл	Газар зохион байгуулалтын чиглэлээр: ✓ УБХ руу Э дугаар авахаар 1 хуулийн этгээдийн холбогдох мэдээллийг илгээсэн. ✓ Төрийн аудитын албан шаардлагад оросн 2 жил газраа ашиглаагүй, холбоо барих мэдээлэл нь өөрчлөгдсөн 34 иргэн хуулийн этгээдэд Захиргааны ерөнхий хуулийн дагуу сонсох ажиллагааг дахин хийж үүнээс өнөөгрсөн 7 хоногт 13 иргэн, хуулийн этгээд ирүүлсэн. Энэ 7 хоногот 6 иргэн, хуулийн этгээд нь хариу тайлбараа ирүүлээд байна. Газрын төлөв байдал, чанарын хянан баталгаа

		✓ Дархан-Уул аймгийн хүчтэй элэгдэл, эвдрэлд орсон нөхөн сэргээх шаардлагатай 80 иргэн, хуулийн этгээдийн тариалангийн газрын судалгааг гаргаж ГЗБГЗЗГ-ын Суурь судалгаа мониторингийн хэлтэст 2020.04.01-ний өдрийн 276 тоот албан бичгээр хүргүүлсэн. ✓ Байгалийн унаган төрх байдлыг алдагдуулж, хүрээлэн буй орчинд болон хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл ихээр үзүүлдэг уул, уурхайн зориулалтаар эзэмшүүлж, ашиглуулсан газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгаа хийх ажлыг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газраас зохион байгуулж байгаатай холбогдуулан 2020 оны 04 дүгээр сарын 14-ны өдрийн дотор тухайн сумын хэмжээнд байгаа уул уурхайн зориулалтаар олгогдсон нэгж талбарын судалгааг авахаар сумдын газрын даамлуудад аймгийн ГХБХБГ-ын даргын 2020.04.02-ны өдрийн 280 тоот албан бичгийг тус тус хүргүүлсэн. Сургалт: ✓ НҮБ-ын Хүнс хөдөө аж ахуйн байгууллагаас зохион байгуулж буй Дэлхийн хөрсний давсжилтийн зураг хийх онлайн сургалтыг Дэлхий 13 улсад явуулж байгаа бөгөөд энэ сургалтанд Монгол улсын талаас ГЗБГЗЗГ-аас Суурь судалгаа, мониторингийн хэлтсийн мэргэжилтэн Д.Мөнхцэцэг, Дархан-ХААИС-ын багш, доктор профессор Б.Энхтуяа, Дархан-УГТЭШХ-ээс хөрсний лабораторийн эрдэм шинжилгээний ажилтан н.Мөнхбат, мөн миний бие үргэлжлүүлэн 2020.03.30-04.03-ны өдрүүдэд өдрийн 12:00-17:30 цагаас хооронд сургалтанд оролцож, Монгол улсын хөрсний холбогдох мэдээлэл дээр ажиллаж сэдэвчилсэн зураг хийж гүйцэтгэсэн. ✓ НҮБ-ын Хүнс хөдөө аж ахуйн байгууллага болон ГЗБГЗЗГ-ын хооронд 2019.12.30-ний өдрийн 2019/92 дугаартай хамтран ажиллах гэрээ байгуулсан. Энэ ажлын хүрээнд “Үндэсний хэмжээний газар ашиглалт, газар ашиглалтын өөрчлөлтийн үнэлгээ” хийх ажлыг 21 аймаг болон нийслэлийн газар зохион байгуулалтын албаны Суурь судалгаа, газрын мониторингийн асуудал хариуцсан мэргэжилтнүүдэд хоёрдугаар шатны Openforis, Collect earth программын сургалтыг 2020.04.01-03-ны өдрүүдэд цахимаар 8.30-17.30 цагийн зохион байгуулж үүнээс Дархан-Уул аймаг 2020.04.01-02-ны өдрүүдэд уг программын сургалтанд оролцсон.
2	Газар зохион байгуулалтын төлөвлөлт, өмчлөлийн чиглэл	✓ Аймгийн Цагдаагийн газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар болон Прокурорын газарт шалгагдаж байгаа иргэн, хуутгээдийн нийт 12 албан бичгийн лавлагааг мэдээллийн сан болон газар өмчлөх захирамжаас шүүж хариуг хүргүүлсэн. ✓ Дархан сумын нутаг дэвсгэрт гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар газар өмчилж аваагүй тухай лавлагааг нийт 134 иргэнд гаргаж өгсөн. ✓ 2020 оны 1-р улирлын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг гарган ГУХ-ын даргад танилцуулсан ✓ Байгууллагын хурал дээр өгсөн үүрэг даалгаврын хүрээнд : Дархан сумын 3-р багийн нутаг дэвсгэрт орших Тосгон Долоо дахь өдрийн адвентист сүм, 15-р баг Б.Нэргүйбаатар , П.Уранбилэг нарын эзэмшил газрын түүхчилсэн судалгааг гаргаж байгууллагын дарга болон ГУХ-ийн даргад танилцуулсан. ✓ Дархан сумын 10-р баг 31-р хороолол дээр шинээр АОС –ны зориулалтаар газар хүссэн нийт 41 иргэний өргөдлийг байгууллагын дарга болон ГУХ-ийн даргад танилцуулсан. ✓ Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын 2020 оны 03 дугаар сарын 03 –ний өдрийн 1/614 тоот албан бичигт “Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим систем”-ийг нэвтрүүлэх тухай 2020 оны Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын А/46

		тушаал, А/40 тушаал болох цахим системийг нэвтрүүлэх журмыг холбогдох мэргэжлийн байгууллага болон аймаг, сумын Засаг дарга, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчид, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын дарга нарт, Аймгийн Ерөнхий архитекторт тус тус цахим системийг нэвтрүүлэх тухай албан бичиг хүргүүлсэн ✓ Дархан сумын нутаг дэвсгэрт "Өмчилсөн газрын талбайн хэмжээ өөрчлөлт оруулах тухай" захирамжийн төслийг аймгийн Хууль эрх зүйн хэлтсийн даргаар санал, дүгнэлт, зөвлөмж өгөх, захирамжийн төслийг хянуулсан. ✓ 2020-03-31 өдөр ГЗБГЗЗГ-аас "Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим систем"-ийг нэвтрүүлэх тухай видо сургалт хийсэн үүнд Дархан ,Орхон, Хонгор, Шарын гол сумын даамлууд, ГУХ-ийн дарга, Хот байгуулалтын кадастрын мэргэжилтэн, ГЗБТ, ГӨ-ийн асуудал хариуцсан мэргэжилтнүүд хамрагдсан
3	Геодези, зураг зүй	✓ Эзэмшил, өмчлөлийн газартай 9 иргэн, аж ахуйн нэгжид кадастарын зураг гаргаж үйлчилсэн. ✓ Шинэ хаягийн зургийн дагуу 7 иргэний эзэмшлийн газарт хаяг дугаар олгосон. ✓ "Өртөөлөн хүргэгч консерцум" дундын хоршооны хоршооноос ирсэн албан бичгийн дагуу Дархан сумын хаянийн зургийг файлаар хүргүүлэв. ✓ Хонгор сумын Зулзгын голын хаягийн зургийн дугаарлалт хийх ажлын хүрээнд 235 иргэн аж ахуй нэгжийн эзэмшлийн газрыг дугаарласан.
4	Кадастр	✓ Дархан суманд гэр бүлийн хэрэгцээний өмчлөх 19 иргэн, хуваасан 2 иргэн, худалдсан, бэлэглэсэн 18, өвөлсөн 1 иргэн, Дархан суманд эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээг 17 иргэн хуулийн этгээдтэй байгуулж, эзэмших эрхийн гэрээ байгуулсан 24 иргэн, хуулийн этгээдэд кадастрын зураг үйлдсэн. ✓ Улсын бүртгэлийн хэлтэст дугаар олгуулахаар 10 иргэн, хуулийн этгээдийн өргөдөл илгээж дугаар олгуулсан ✓ Орхон суманд гэр бүлийн хэрэгцээний өмчлөх 1 иргэний кадастрын зургийг тус тус гаргаж өгсөн.
5	Газрын татвар, төлбөр, үнэлгээ	- Аймгийн хэмжээнд 2020.04.09-ний өдрийн хугацаанд нийт 1065 ИААНБ-ын 3922 нэхэмжлэл үүсгэж, 612.4 сая төгрөгийн нэхэмжлэл үүсгэж, Татварт илгээсэн байна. /**2020.04.01-2020.04.09**-ний өдрийн хооронд 57 ИААНБ-ын 210 нэхэмжлэл үүсгэж **98.8** сая төгрөгийн нэхэмжлэл үүсгэж Татварт илгээсэн байна/ - ГЗБГЗЗГ-аас нэхэмжлэл үүссэн алдааг засварлах 31 нэгж талбарын судалгаа ирүүлснийг шалгаж засварласан. - 2020.01.01-2020.04.07-ний хугацаанд гэрээ байгуулсан нийт 281 нэгж талбарын төлбөрийн мэдээллийг шалгаж, программ ногдуулалт хийхээс 170 нэгж талбарт цахимаар нэхэмжлэл үүсгэж Татварт илгээсэн ба 70 нэгж талбар хөрөнгийн алдаа зааж нэхэмжлэл үүсээгүйг ГЗБГЗЗГ-т судлуулахаар уламжилсан, 41 нэгж талбар нь газрын төлбөрийн дутуу төлөлттэй учраас нэхэмжлэл үүсгэх боломжгүй байна. - Цаашид нэхэмжлэл үүсэх боломжтой, газрын төлбөрийн өргүй нэгж талбарын судалгааг сум тус бүрээр гаргаж ажиллах, урьд оны өр авлагатай ИААНБ-тай газрын төлбөрийн тооцоо нийлж ажиллах төлөвлөгөөтэй байна.

Захиргаа удирдлагын хэлтэс		
1	Хүний нөөц, хууль эрх зүй, дотоод ажил	✓ Аймгийн онцгой байдлын 7 хоногийн мэдээллийг хүргүүллээ ✓ Хариуцлагатай жижүүрийн хуваарийг дахин 1 сараар сунгаж газрын даргын тушаалын хэрэгжилтийг хангуулж ажиллаж байна. ✓ ГЗБГЗЗГ-аас ирүүлсэн 30 заалт бүхий зөвлөмжийн хэрэгжилтийг зохион байгуулж ажиллаж байна. ✓ МУ-ын үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг мэдээ, мэдээллээр хангах орон тооны байнгын ажлын хэсгийн 2020 оны ажлын төлөвлөгөөнд тусгуулах саналыг боловсруулж хүргүүлхээр ажиллаж байна.
2	Мэдээллийн технологи, нярав	Мэдээлэл: 1. 70376471 нээлттэй утсаар 5 иргэн, ААНБ-ын асуултанд хариулт өгөв. 2. Байгууллагын Facebook хуудсанд ирсэн 2 иргэний асуултанд хариулт өгөв. Мэдээлэл технологийн чиглэлээр: 1. Байгууллагын цахим хуудсанд байгууллагын 3-р сарын 1, 2, 3, 4-р долоо хоногийн, байгууллагын 3-р сарын тайлан, 3-р сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээг тавив. 2. Сумдын даамлуудыг цахим хуралд оролцуулахад шаардлагатай програмыг компьютер дээрээ суулгаж, хуралд оролцоход мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж заавар, зөвлөгөө өгч ажиллав. Нярав: 1. 30 ширхэг Нэгж талбарын хувийн хэрэг нугалав. 2. Газрын удирдлагын хэлтсийн мэргэжилтнүүдэд 192 ширхэг кадастрын үнэт цаас, 25 ширхэг НТХХ, 22 ширхэг газар эзэмших гэрчилгээ /Иргэн/, 13 ширхэг газар эзэмших гэрчилгээ /ААНБ/, 1 ширхэг ширхэг газар эзэмших гэрчилгээ /ТБ/, Шарын гол сумын даамалд 30 ширхэг кадастрын үнэт цаас, 12 ширхэг газар эзэмших гэрчилгээ /Иргэн/, Орхон сумын даамалд 100 ширхэг кадастрын үнэт цаас тус тус олгов. 3. Шаардах хуудсаар 16 төрлийн 76 ширхэг бараа материал олгов. 4. 3-р сарын үнэт цаас, бараа материалын тайлангийн нэгтгэлийг гаргаж ня-бо-д өгөв. Шинээр авсан бараа материал, агентлагаас ирсэн бараа материалыг хүлээн авч агуулахад хураав.

Тайлан боловсруулсан: ЗХАХМэргэжилтэн Б.Золбаясах

Хянасан: ГУХ-ийн дарга Г.Нямдорж